

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2012 оны 5 дугаар сарын 31

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2012 оны 5 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

/тоогоор/					
№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2012-04 сар	Нэмэгдсэн	Хасагдсан	2012-05 сар
1	Даатгалын компани	18			
2	Даатгалын компанийн салбар	188	2 ¹		190
3	Даатгалын төлөөлөгч	2069	91 ²	1 ³	2159
4	Даатгалын зуучлагч	11	1 ⁴		12
5	Даатгалын хохирол үнэлэгч	9			
6	Актуарч	15			
7	Бусад	15			

Тайлант үед даатгалын компани, даатгалын компанийн салбарын тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹Хорооны 2012 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 116 дугаар тушаалаар “Бодь даатгал” ХХК-д Ховд аймгийн Жаргалант суманд, Хорооны 2012 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 117 дугаар тушаалаар “Мандал женерал даатгал” ХХК-д Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт тус тус даатгалын салбар нээн ажиллуулах тусгай зөвшөөрөл олгосон байна.

²Хорооны 2012 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 94 дүгээр тушаалаар “Ард даатгал” ХХК-ийн 21 иргэнд, Хорооны 2012 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 98 дугаар тушаалаар “Гэр даатгал” ХХК-ийн 6 иргэнд, Хорооны 2012 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 120 дугаар тушаалаар “Ард даатгал” ХХК-ийн 64 иргэнд тус тус даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгосон байна.

³Хорооны 2012 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 93 дугаар тушаалаар “Миг даатгал” ХХК-ийн 1 иргэний даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

⁴Хорооны 2012 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 143 дугаар тогтоолоор “Си Эн Эн Икс” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгов.


2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2012 оны 01 дүгээр сараас 2012 оны 05 дугаар хүртэлх даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг харуулбал :


Ердийн даатгалын компаниудын хувьд :		
		/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	5-р сар	Өссөн дүнгээр
Даатгалын нийт хураамж	8,354,923.30	32,339,663.00

Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж	2,249,769.90	5,838,348.10
Олгосон нийт нөхөн төлбөр	1,174,604.80	5,404,164.50
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	187,364.70	456,892.80
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	480.00	1,044.00
Давхар даатгалд төлсөн хураамж	1,010,776.50	7,951,013.50
Байгуулсан даатгалын гэрээний тоо	72,507.00	169,795.00
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо	53,970.00	116,421.00
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	62,356.00	140,472.00
Хамгийн өндөр дүнтэй даатгалын гэрээ		
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	214,222,226.90	241,222,226.90
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	223,202.90	240,088.20

2012 оны 05 дугаар сарын байдлаар даатгалын хураамжийн орлого 2011 оны мөн үеийнхээс 5049.3 сая төгрөгөөр буюу 2.5 дахин өссөн байна. Жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлого өмнөх сараас 35 хувиар өсөж, оны эхний 5 сарын байдлаар нийт 5838.3 сая төгрөг болсон байна.



2012 оны 05 дугаар сарын байдлаар даатгалын нөхөн төлбөр 2011 оны мөн үеэс 444.9 сая төгрөгөөр буюу 1.6 дахин өссөн. Жолоочийн албан журмын даатгалын нөхөн төлбөр өмнөх сараас 1.6 дахин өсөж, өссөн дүнгээр 456.9 сая төгрөгт хүрсэн байна.




2012 оны 05 дугаар сард “Хаан даатгал” ХХК шинээр даатгалын гэрээ байгуулаагүй, даатгалын хураамжийн орлого болон даатгалын нөхөн төлбөргүй ажилласан байна.


Ердийн даатгалын компаниудын 2012 оны 05 дугаар сард байгуулсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Практикал даатгал” ХХК-ийн байгуулсан 147.8 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын гэрээ бөгөөд “Монгол даатгал” ХХК нь хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр болох 68.5 сая төгрөгийг олгосон байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

Үзүүлэлт	5-р сар	Нийт дүн
Даатгалын нийт хураамж	55,970,437	240,600,181
Олгосон нийт нөхөн төлбөр	6,532,000	57,657,689
Давхар даатгалд төлсөн хураамж	1,915,716	23,425,817
Байгуулсан даатгалын гэрээний тоо	15	81
Хувь хүний хугацаат даатгалд	3	19
Байгууллагын хугацаат даатгалд	4	15
Өндөр хамгаалалттай ЭМД-д	0	0
Эмнэлгийн мөнгөний даатгалд	6	18
Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	2	16
Тэтгэврийн даатгалд	0	9
Орон сууцны даатгалд	0	2
Хуримтлалын даатгалд	0	2
Зээлдэгчийн амь насны даатгалд	0	0
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	20,000,000	400,000,000
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	1500 000	12,510,000



Урт хугацааны даатгагчийн даатгалын хураамжийн орлого 2012 оны 05 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 14.1 сая төгрөгөөр буюу 1.3 дахин өссөн байна.



2012 оны 05 дугаар сарын байдлаар урт хугацааны даатгалын нөхөн төлбөр 2011 оны мөн үеэс 1.7 сая төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

/төгрөгөөр/

Үзүүлэлт	5-р сар	Нийт дүн
Даатгуулагчаас шууд орж ирсэн дүн даатгалын хураамж	118,465,008	335,299,732
Даатгалын зуучлагчийн орлого	39,244,272	184,277,135
Зуучилсан даатгалын гэрээний тоо	1,726	2,241
Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	580,529,493	6,683,350,000

2012 оны 5 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 39.2 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон ба өмнөх оны мөн үеийнхээс 3.7 сая төгрөгөөр буюу 1.1 дахин өссөн байна.

Даатгалын зуучлагч компаниудаас хамгийн өндөр дүнтэй буюу 580.5 сая төгрөгийн үнэлгээтэй 74.6 сая төгрөгийн хураамж бүхий даатгалын гэрээг “Лояалти солюшн” ХХК зуучлан борлуулсан байна.

Тайлант хугацаанд “Монголиан интернэшнл брокерс” ХХК нь 05 дугаар сарын мэдээ ирүүлээгүй болно.

Мөн 2012 оны эхний улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл авсан “Нэйшнл эженси” ХХК, “Юу ай би” ХХК, “Тэрэлт буян ундрах” ХХК-иуд тус тус мэдээг ирүүлээгүй байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

/төгрөгөөр/

Үзүүлэлт	5-р сар	Нийт дүн
Даатгалын хохирол үнэлэсний орлого	9,628,400	38,609,364
Үнэлсэн даатгалын хохиролын тоо	546	2,076
Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн		143,841,281

2012 оны 05 дугаар сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 9.6 сая төгрөгийн орлоготой ажиллаж, өмнөх оны мөн үеэс 5.5 сая төгрөгөөр буюу 2.3 дахин өссөн байна.

Тайлант хугацаанд “Арвижих эстимэйт” ХХК, “Итгэлт эстимэйт” ХХК, “Файн эстимэйт” ХХК мэдээ ирүүлээгүй байна.

3. БУСАД

Хорооны 2012 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 140 дүгээр тогтоолоор “Хорооны 2009 оны 211 дүгээр тогтоолоор батлагдсан Төлбөрийн чадварын тооцох журам”-д нэмэлт өөрчлөлт орсон.

Хорооны 2012 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 141 дүгээр тогтоолоор “Хорооны 2009 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-д нэмэлт өөрчлөлт орсон.

Хорооны 2012 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 142 дугаар тогтоолоор “Тэнгэр даатгал” ХХК-д дүрмийн сангийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөв.

Хорооны 2012 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 158 дугаар тогтоолоор “Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоол”-д нэмэлт өөрчлөлт оруулав.

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН МЭДЭЭ

4. ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2012 оны 5 дугаар сард Хорооноос даатгалын компаниудад жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэмж олгоогүй учир зөвшөөрөл эзэмшигчдийн тоонд өөрчлөлт ороогүй байна. Жолоочийн хариуцлагын албан журмын

даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй компаниудыг цагаан толгойн үсгийн дарааллаар жагсаан харуулбал:

1. “Ард даатгал” ХХК
2. “Бодь даатгал” ХХК
3. “Ган зам даатгал” ХХК
4. “Гэр даатгал” ХХК
5. “Мандал женерал даатгал” ХХК
6. “Миг даатгал” ХХК
7. “Монгол даатгал” ХХК
8. “Моннис даатгал” ХХК
9. “Монре даатгал” ХХК
10. “Мөнх даатгал” ХХК
11. “Номин даатгал” ХХК
12. ”Практикал даатгал” ХХК
13. “Соёмбо даатгал” ХХК
14. “Тэнгэр даатгал” ХХК
15. ”Улаанбаатар хотын даатгал” ХХК


5. ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ:

2012 оны 5 дугаар сард даатгалын компаниуд нийт 8,354,923,272.0 төгрөгийн даатгалын хураамж олж, 1,174,604,807.5 төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосноос жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 59,737 даатгалын гэрээнээс 2,249,769,866.2 төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлж, 480 даатгуулагчийн бусдад учруулсан хохиролд 187,364,640.0 төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

2012 оны эхний 5 сарын байдлаар нийт 122,188 жолоочийн даатгалын гэрээ байгуулагдаж, тэдгээрээс 5,838,348,130.9 төгрөгийн даатгалын хураажийн орлого даатгагчдад төвлөрч, 1,044 даатгуулагчийн бусдад учруулсан хохиролд 456,892,798.0 төгрөгийн нөхөн төлбөр олгосныг доорх хүснэгтэд задалж үзүүлье:

Үзүүлэлт	Жолоочийн даатгалын хураамжийн орлого	Жолоочийн даатгалын гэрээний тоо	Жолоочийн даатгалын нөхөн төлбөр	/төгрөгөөр/
				Жолоочийн даатгалын нөхөн төлбөр гаргуулсан даатгуулагчийн тоо
2012-1 сар	332,507,006.1	7,201	11,177,915.0	13
2012-2 сар	512,329,506.4	9,840	42,569,350.0	99
2012-3 сар	1,080,618,814.9	14,869	98,942,326.0	183
2012-4 сар	1,663,122,937.3	30,541	116,838,567.0	269
2012-5 сар	2,249,769,866.2	59,737	187,364,640.0	480
НИЙТ	5,838,348,130.9	122,188	456,892,798.0	1,044

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагчдын төвлөрүүлсэн жолоочийн даатгалын хураамж болон олгосон нөхөн төлбөрийн өсөлтийг 2012 оны эхний 5 сарын байдлаар графикаар үзүүлье /сая төгрөгөөр/:



Дээрхээс үзэхэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай холбоотой бүхий л үзүүлэлтүүд сар бүр өссөн боловч нөгөө талаасаа даатгалд хамрагдах хугацаа болох 9 сарын дийлэнх буюу 5 сар нь өнгөрсөн байхад хамралт хангалтгүй байна.

ДААТГАЛЫН ГАЗАР